



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 19/02

Чойбалсан хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Адуунчулуун” ХК-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Адуунчулуун” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04-р сарын 22-ны өдрийн 14:00 цагт Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, “Адуунчулуун” ХК-ийн хурлын танхимд зарлан хуралдуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсүгэй:
 - A. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,
 - B. Нэгж хувьцаанд ногдол ашиг хувиарлах хэмжээ батлах, тараах хугацааг тогтоох тухай,
 - C. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох /кумулятив аргаар/,
 - D. Бусад асуудал /КтХ-ийн 62.1 дэх заалт/
3. Хурал хуралдуулах тухай Хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, диллерийн компаниудад мэдэгдэх хугацааг 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөр, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа

эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн хугацааг 2019 оны 04-р сарын 03-ний өдрөөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн хугацааг 2019 оны 04-р сарын 22-ны өдөр 14:00 цагт байхаар тус тус тогтоосугай.

4. "Адуунчулуун" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудас, Өдрийн сонинд 2019 оны 3-р сарын 15-ны өдөр тус тус нийтлүүлэхийн зэрэгцээ давтан зарыг 3-р сарын 29-ны өдөр Өдрийн болон орон нутгийн сонин радио, телевизд тус тус мэдээлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад хариуцуулсугай.
5. Хувьцаа эзэмшигчид Хувьцаа эзэмшигчдийн хурлын бичиг баримттай 2019 оны 04 дүгээр сарын 15-наас хойш компани дээр ирж танилцаж болохыг дурьдсугай. /Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт г.м/
6. "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай" журмын дагуу хурлын зарыг хүргэж, хурлыг бэлтгэл сайтай явуулахыг хурал зохион байгуулах комисс, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Гангамөрөн, "Адуунчулуун" ХК-ийн удирдлага, холбогдох албан тушаалтан нарт тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ШАТАР



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 19/03

Чойбалсан хот

Ногдол ашиг хувиарлах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт, “Адуунчулуун” ХК-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус удирдлага болгон, Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцээд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Тус компани тайлант хугацаанд 547,0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласныг тэмдэглэх нь зүйтэй.
2. Компанийн цэвэр ашгийн 75 хувь буюу 409669520 төгрөгийг, нэгж хувьцаанд 130 төгрөгөөр ногдол ашигийг хувиарлах нь зүйтэй гэж үзээд уг асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хувиарлах, олгох ажлыг холбогдох хуулийн дагуу 2019 онд багтаан авч хэрэгжүүлэхийг компанийн удирдлагад хариуцуулсугай.

ДАРГА



Б.ШАТАР



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 19/04

Чойбалсан хот

Хурлын дарга, тооллогын комисс
томилох тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Б.Шатарыг, бүрэлдэхүүнд М.Шинэтогтох, Б.Батсайхан нарыг тус тус томилсугай.
2. Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:
Дарга:
“Адуунчулуун” ХК-ийн компьютерийн инженер Э.Баяржаргал
Гишүүд:
“Адуунчулуун” ХК-ийн ШТМ-ын нярав Ү.Ариунбат
“Адуунчулуун” ХК-ийн хүнд машин механизмын засварын механик М.Мөнхбаяр
3. Хуралд оролцохоор биеэр ирсэн Хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хэлэлцэж буй асуудлуудад саналаа өгөх бөгөөд саналын хуудсыг бөглөхдөө хэлэлцэх асуудал тус бүрт өөрийн эзэмшиж буй хувьцааны тоогоор саналаа өгч гарын үсэг зурж баталгаажуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.ШАТАР